

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2026 оны 03 дугаар сарын 30 -ны өдрийн А/157 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Дотоод хэргийн их сургууль /цаашид “ДХИС” гэх/-ийн 2026-2027 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Элсэлтийг зохион байгуулахад Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, мөн сайдын 2026 оны “Босго оноо тогтоох тухай” А/34 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, ДХИС-ийн захирлын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам” болон бусад холбогдох акт болон энэхүү журмыг баримтална.

1.3.Элсэлтийн үйл ажиллагааг Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хилчний гудамж /бүсчлэлийн код 13260/-д байрлах ДХИС-ийн байрлалд зохион байгуулна.

1.4.Элсэлтийн шалгалттай холбоотой мэдээллийг ДХИС-ийн www.uia.gov.mn цахим хуудас, “Дотоод хэргийн их сургууль | University of Internal Affairs” фэйсбүүк хуудас, www.elselt.uia.gov.mn элсэлтийн системээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Хоёр.Элсэгчид тавигдах шаардлага

2.1.Элсэгч дараах нийтлэг шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна:

2.1.1.элсэлтийн журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлсэн байх;

2.1.2.элсэгчийн элсэлтийн шалгалт /цаашид “ЭШ” гэх/-ын оноо нь энэ журмаар тогтоосон босго онооноос багагүй байх;

2.1.3.элсэлтийн шалгалтын оноо хүчинтэй байх (2024, 2025, 2026 он), Монгол хэл, бичгийн шалгалтын босго оноог хангасан байх;

2.1.4.элсэгч нь Төрийн байгууллагуудын мэдээллийн санд байгаа өөрийн хувийн мэдээллийг албан хэрэгцээнд зориулан төрийн байгууллагуудын мэдээллийн систем хооронд дамжуулан ашиглахыг зөвшөөрсөн байх.

2.2.Элсэгчид дараах тусгай шаардлагыг хангасан байна:

2.2.1.элсэгч эрэгтэй 17-26 хүртэл настай, эмэгтэй 17-26 хүртэл настай байх;

2.2.2.элсэгчийн биеийн өндөр хүснэгт №1-д заасан хэмжээнээс доошгүй байх;

Хүснэгт №1

№	Элсэлт авах хөтөлбөрийн нэр	Эрэгтэй	Эмэгтэй
1	Цагдаа судлал	170 см	160см
2	Мөрдөх алба		
3	Кибер гэмт хэрэг судлал		
4	Дотоодын цэрэг судлал	165 см	160 см
5	Хил судлал	165 см	-
6	Шалган нэвтрүүлэх алба	170 см	-
7	Хил хамгаалалтын инженерийн байгууламж, техник хэрэгслийн ашиглалт	165 см	-
8	Эдийн засаг	165 см	160см
9	Сэтгэл судлал	165 см	160см
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	165 см	160 см
11	Аюулгүй байдал судлал		
12	Нийгмийн ажил		
13	Онцгой байдал-гамшиг судлал	170 см	-
14	Шинжлэн магадлах ухаан	165 см	160 см

2.2.3.нэмэлт шалгалт (эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн сорил, ярилцлага)-д тэнцсэн байх;

2.2.4.ял шийтгүүлж байгаагүй байх;

2.2.5. ДХИС-ийн аль нэг хөтөлбөрт суралцаж сахилга, ёс зүйн зөрчлөөр сургалтаас хасагдаагүй байх;

2.2.6.энэ журмын 12.1-т заасан зардлыг хариуцан төлөхийг хүлээн зөвшөөрсөн байх.

2.3.“Эрх зүй” хөтөлбөрт элсэгч журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.2.4-т заасан шаардлагыг хангасан байна.

2.4.Энэ журмын нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг бүртгэлээс хасах ба элсүүлэн суралцуулахгүй.

Гурав.Элсэлт авах хөтөлбөр, суралцагч элсүүлэх хяналтын тоо, элсэлтийн шалгалтын босго оноо

3.1.ДХИС-д элсэгчдийг хүснэгт №2 заасан хөтөлбөр, элсэлтийн шалгалтын босго оноо, хяналтын тооны хүрээнд зохион байгуулах бөгөөд нийт хяналтын тооны 10%-д ДХИС-ийн харьяа “Ахлах сургууль”-иас элсүүлнэ.

Хүснэгт №2

Д/д	Элсэлт авах хөтөлбөр	Суралцах хугацаа	Хяналтын тоо					Элсэлтийн шалгалтын нэр, босго оноо	
			Нийт	Иргэдээс		ДХИС-ийн харьяа Ахлах сургуулиас		ЭШ-1 Суурь (70%)	ЭШ-2 Хавсарга (30%)
				эр	эм	эр	эм		
3.1.1. Цагдаагийн сургууль									
1	Цагдаа судлал	4 жил	226	164	40	18	4	Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл-480 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
2	Мөрдөх алба		25	18	4	2	1	Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл-500 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
3	Кибер гэмт		25	18	4	2	1	Математик,	Ур чадвар-500

	хэрэг судлал								Англи хэл-500 /аль өндөр оноогоор/	
4	Дотоодын цэрэг судлал		44	32	7	4	1		Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл-450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
3.1.2. Хилийн албаны сургууль										
1	Хил судлал	4 жил	35	31	0	4	0		Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл-450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
2	Шалган нэвтрүүлэх алба		30	27	0	3	0		Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл-450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
3	Хил хамгаалалтын инженерийн байгууламж, техник хэрэгслийн ашиглалт		15	13	0	2	0		Нийгэм судлал, Математик, Англи хэл-450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
4	Эдийн засаг		15	10	3	1	1		Математик-490	Нийгэм судлал, Англи хэл-490 /аль өндөр оноогоор/
5	Сэтгэл судлал		15	10	3	1	1		Нийгэм судлал, Математик-490 /аль өндөр оноогоор/	Монгол хэл, Англи хэл-490 /аль өндөр оноогоор/
3.1.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль										
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	4 жил	40	23	14	2	1		Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл- 450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
2	Аюулгүй байдал судлал		20	18	0	2	0		Нийгэм судлал, Монгол хэл, Англи хэл- 450 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
3	Нийгмийн ажил		15	9	4	1	1		Нийгэм судлал, Англи хэл-490 /аль өндөр оноогоор/	Монгол хэл, Математик- 500 /аль өндөр оноогоор/
3.1.4 Онцгой байдлын сургууль										
1	Онцгой байдал-гамшиг судлал	4 жил	40	36	0	4	0		Нийгэм судлал, Монгол хэл, Математик- 450 /аль өндөр	Ур чадвар-500

								оноогоор/	
3.1.5 Шинжлэн магадлах ухааны сургууль									
1	Шинжлэн магадлах ухаан	4 жил	25	18	4	2	1	Нийгэм судлал, Монгол хэл, Математик-480 /аль өндөр оноогоор/	Ур чадвар-500
3.1.6 Хууль зүйн сургууль									
1	Эрх зүй	4 жил	90	81			9	Нийгэм судлал-500	Математик, Англи хэл-500 /аль өндөр оноогоор/

Дөрөв.Элсэлтийн бүртгэл

4.1.Элсэгч elselt.uia.gov.mn цахим хаягаар нэвтэрч Боловсролын үнэлгээний төвийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ.

4.2.Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын “Ахлах сургууль”-ийн төгсөгч бол elselt.uia.gov.mn цахим хуудасны “Ахлах сургууль” хэсгийг сонгон бүртгүүлнэ.

4.3.Цахим бүртгэл 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 08:00 цагаас 2026 оны 06 дугаар сарын 28-ний 17:00 цаг хүртэл үргэлжилнэ.

4.4.Элсэгч нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан хөтөлбөрүүдээс зөвхөн нэг хөтөлбөрийг сонгон бүртгүүлнэ.

4.5.Элсэгч нь элсэлтийн бүртгэлд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг ДХИС хариуцахгүй.

4.6.Элсэгч нь элсэлтийн системд бүртгүүлэхэд бүртгэлийн хураамж төлөхгүй бөгөөд ЭШ-ын онооны эрэмбээр жагсаалт гарч хяналтын тоонд багтсан тухай мэдэгдэл авсан тохиолдолд бүртгэл баталгаажуулах хураамжийг elselt.uia.gov.mn системээр дамжуулан төлнө.

4.7. Бүртгэл баталгаажуулалтын хураамж 30.000 төгрөг байна. Хураамжийг буцааж олгохгүй.

Тав.Элсүүлэх үе шат

5.1.Бакалаврын элсэлтийг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

д/д	Үе шат	Эхлэх, дуусах хугацаа	Байрлал	Нэмэлт тайлбар
5.1.1.	ЭШ-ын оноогоор эрэмбэлж жагсаалт гаргана.	2026.06.29-ний өдөр (Боловсролын үнэлгээний төвөөс ЭШ-ын дүн өгөх хугацаанаас шалтгаална)	elselt.uia.gov.mn n	Хяналтын тоог 50 хувь хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны бүртгүүлэгчийн тухайн хөтөлбөрт хамаарах ЭШ-ын хичээлээр авсан онооны аль өндрийг нь авч буурах дарааллаар эрэмб элэн жагсааж, тэнцсэн болон тэнцээгүй бүртгүүлэгчдэд бүртгүүлсэн и-мэйл болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ.
5.1.2.	Бүртгэл баталгаажуулалт	ЭШ-онооны жагсаалт гарснаас хойш 4 цаг	elselt.uia.gov.mn n	Тэнцсэн тухай мэдэгдэл авсан бүртгүүлэгчдэд бүртгэл баталгаажуулах эрх нээгдэнэ. Эрх нээгдсэнээс хойш 4

				цагийн дотор elselt.uia.gov.mn сайтад нэвтэрч, "Бүртгэл баталгаажуулах" сонголтыг хийснээр нэмэлт шалгалтад орох эрх үүснэ.
5.1.3.	Бүртгэл баталгаажсан бүртгүүлэгчдэд мэдээлэл хүргэх	Баталгаажуулалт хаагдсан өдөр	elselt.uia.gov.mn п	Бүртгэл баталгаажуулж нэмэлт шалгалтад хамрагдах элсэгчдэд бүртгүүлсэн и-мэйл болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ.
5.1.4.	Эрүүл мэндийн анхан шатны үзлэг, шинжилгээ	2026.06.30-03-ны 08.30 цагаас 17.00 цаг хүртэл	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг ТТАХНЭ-ийн комисс зохион байгуулна.
5.1.5.	Ур чадварын шалгалт	2026.07.02-08 ны 08.30 цагаас 17.00 цаг хүртэл	Дотоод хэргийн их сургууль	Хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоонд багтаж, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тэнцсэн элсэгч ур чадварын шалгалтад орох эрх үүснэ.
5.1.6.	Сэтгэл зүйн сорил, ярилцлага	2026.07.06-ны 08.30 цагаас 2026.07.08-ны 17.00 цаг хүртэл		Ур чадварын шалгалтад тэнцсэн элсэгч сэтгэл зүйн сорил, ярилцлагад орох эрх үүснэ.
5.1.7.	Хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрт нэмэлт баталгаажуулалтыг зохион байгуулах. /Хяналтын тоо гүйцсэн тохиолдолд нэмэлт баталгаажуулалт явагдахгүй/	2026.07.04-ний өдрийн 09:00 цагаас 15:00 цаг хүртэл	elselt.uia.gov.mn	Нэмэлт баталгаажуулалтад ЭШ-ын оноогоор тэнцсэн боловч хяналтын тоонд багтаагүй болон бүртгэл баталгаажуулалтаас хоцорсон бүртгүүлэгчдийг хамруулна.
5.1.8.	Нэмэлт шалгалт: (хугацааг тухай бүр зарлана)			
5.1.9.	Нэмэлт шалгалтад хамрагдаж, тэнцсэн элсэгчдийн бүртгэл	2026.07.09-ний өдөр	Дотоод хэргийн их сургууль	Энэ журмын 5.12-т заасан материалыг бүрдүүлэн биеэр ирж баталгаажуулна.
5.1.10.	Чиглүүлэх сургалт	2026.07.09-ний өдөр		Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт болон сургалтын үйл ажиллагааг танилцуулах сургалт.
5.1.11.	Хувцасны хангалт	2026.07.20-21-нд		Бүртгэл баталгаажуулсан элсэгчдэд хувцасны хангалт олгоно.
5.1.12.	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт	2026.07.24-ны өдрөөс 2026.08-24-ны хооронд	Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв	Энэ журмын 8 дугаар бүлгийг үзнэ үү.
5.1.13.	Элсүүлэн суралцуулах, сонсогч цол олгох тухай тушаал гаргах	2026.08.26-ны өдөр	Дотоод хэргийн их сургууль	Цэргийн тангараг өргөснөөр элсэлтийн шалгалтад тэнцсэнд тооцож Их сургуулийн захирлын тушаалаар элсүүлэн суралцуулна.

5.2. Элсэгчдийг хөтөлбөр тус бүрээр энэ журмын 3 дугаар бүлэгт заасан ЭШ-

ын 2-3 хичээлийн онооны аль өндрийг нь тооцож, буурах эрэмбээр жагсаан, хяналтын тоог 50 хүртэл хувь нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэгчдэд хөтөлбөр баталгаажуулах эрх нээнэ; (хяналтын тоо 100 байх тохиолдолд элсэгчдийн жагсаалтын эхний 150-д багтсан элсэгч)

5.3.Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. “Суурь” шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.7, “Хавсарга” шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.3-аар үржүүлж, нэмсэн нийлбэрээр тооцоолсон оноог бодно.

5.4.Оноо тэнцсэн тохиолдолд ЭШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох бөгөөд гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноо, суурь хичээлийн оноо, суурь хичээлийн гүйцэтгэл, монгол хэл бичгийн оноо, монгол хэл бичгийн гүйцэтгэл ЭШ дундаж оноог харгалзана.

5.5.Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж тэнцсэн тухай мэдэгдэл авснаас хойш 4 цагийн дотор элсэх эрхээ баталгаажуулна. Энэ хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд элсэгчийг ДХИС-д элсэхээс татгалзсан гэж үзэж, жагсаалтад байгаа дараагийн бүртгүүлэгчдэд элсэх эрхийг шилжүүлнэ.

5.5.1.цагдаагийн сургуулийн хөтөлбөрт элсэгчдийн нэрийг Цагдаагийн байгууллагад хүргүүлж, судлуулна.

5.5.2.цагдаагийн байгууллагаас Цагдаагийн сургуулийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийн хувийн байдлын талаарх мэдээллийг нягталж, саналаа энэхүү журмын 10.1-д заасан элсэлтийн шалгалын комисс-т хүргүүлнэ.

5.6.Бүртгэл баталгаажуулахад энэ журмын 4.7-д заасан төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна.

5.7.Бүртгэл баталгаажуулах тогтоосон хугацааг мэдээгүй, хоцорсон нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй бөгөөд тухайн гарах үр дагаврыг бүртгүүлэгч өөрөө хариуцах болно.

5.8.Хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрт нэмэлт баталгаажуулалтыг зохион байгуулна. Нэмэлт баталгаажуулалтад энэ журмын 3.1-т заасан хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрүүдэд ДХИС-ийн элсэлтийн цахим хуудсанд бүртгүүлсэн анхны хөтөлбөрт ЭШ-ын онооны эрэмбээр хяналтын тоонд багтаагүй болон хяналтын тоонд багтсан боловч бүртгэл баталгаажуулаагүй бүртгүүлэгчдэд боломжийг олгоно.

5.8.1.нэмэлт баталгаажуулалтад анхны сонгосон болон бусад боломжит хөтөлбөрүүдийг ЭШ-ын оноог эрэмбэлэн жагсаасан дүнгээр санал болгоно.

5.9.Хяналтын тоонд багтсан боловч элсэлтийн нэмэлт шалгалт (Эрүүл мэндийн анхан шатны үзлэг, шинжилгээ, Ур чадварын шалгалт, Сэтгэл зүйн сорил)-д тэнцээгүй элсэгч нь нэмэлт эрэмбэлэлтэд хамрагдахгүй.

5.10.Дотоод хэргийн их сургуулийн харьяа “Ахлах сургууль”-ийн төгсөгчид 3.1-т заасан хяналтын тооны хүрээнд ЭШ-ын оноогоор эрэмбэлж, жагсаалт гаргана. Энэхүү эрэмбэд зөвхөн 2026 оны төгсөгчид хамрагдана.

5.10.1.ДХИС-ийн харьяа “Ахлах сургууль”-д хуваарилсан хяналтын тоо гүйцээгүй тохиолдолд тухайн хяналтын тоог энэ журмын 5.1.7-д заасан нэмэлт баталгаажуулалтын хяналтын тоонд шилжүүлнэ.

5.10.2.ДХИС-ийн харьяа “Ахлах сургууль” төгсөгчид энэ журмын 2 дугаар бүлэгт заасан элсэгчдэд тавигдах нийтлэг болон тусгай шаардлыг хангасан байна.

5.11.“Нийгмийн ажил” “Эдийн засаг” “Сэтгэл судлал” хөтөлбөрт элсэгчид энэ журмын 7.2-т заасан нэмэлт шалгалтад хамрагдана.

5.12.Нэмэлт шалгалтад тэнцсэн тухай мэдэгдэл хүлээн авсан элсэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн энэ журмын 5.1.9-д заасан хугацаанд биечлэн ирж бүртгүүлнэ:

5.12.1.иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;

5.12.2.бүрэн дунд боловсролын гэрчилгээ эх хувь;

5.12.3.хувийн хэрэг эх хувь;

5.12.4.цээж зураг - 3x4 хэмжээтэй 2 хувь;

5.12.5.сургалтын удирдлага, мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөр, Arton англи хэлний хөтөлбөрийн ном, сурах бичгийн төлбөр төлсөн байх

Санамж: Сургалтын удирдлага мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөрийг elselt.uia.gov.mn-элсэлтийн системээр төлнө.

5.13.“Эрх зүй” хөтөлбөрт суралцагч элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

д/д	Үе шат	Эхлэх, дуусах хугацаа	Байрлал	Нэмэлт тайлбар
5.13.1	Цахим бүртгэл	2026.05.01-ний 08.00 цагаас 2026.06.28-ны 17.00 цаг хүртэл	elselt.uia.gov.mn	БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан цахимаар бүртгүүлнэ. (аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй)
5.13.2	ЭШ-ын оноогоор эрэмбэлж жагсаалт гаргана.	2026.06.29-ний өдөр (Боловсролын үнэлгээний төвөөс ЭШ-ын дүн өгөх хугацаанаас шалтгаална)	elselt.uia.gov.mn	Хяналтын тоог 50 хувь хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны бүртгүүлэгчийн онооны дарааллаар эрэмбэлэн жагсааж, бүртгэл баталгаажуулах эрх нээнэ
5.13.3	Бүртгэл баталгаажуулалт	ЭШ-онооны жагсаалт гарснаас хойш 48 цаг	elselt.uia.gov.mn	Тэнцсэн болон тэнцээгүй бүртгүүлэгчдэд бүртгүүлсэн и-мэйл болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ. Тэнцсэн мэдэгдэл авснаар хойш 48 цагийн дотор elselt.uia.gov.mn -ээр бүртгэл баталгаажуулах сонголтыг хийснээр нэмэлт шалгалтад орох эрх үүснэ.
5.13.4	Тэнцсэн элсэгчийн бүртгэл	2026.07.08-ны өдрийн 09.00-17.00 цагт	Дотоод хэргийн их сургууль	Энэ журмын 5.15, 9.4 дахь хэсэг, 12, 14 дугаар бүлгийг үзнэ үү.

5.14.Элсэгчдийг хөтөлбөр тус бүрээр ЭШ-ын 2 хичээлийн онооны аль өндрийг нь тооцож, буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоог 50 хувь нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэгчийг дуудна; (хяналтын тоо 60 байх тохиолдолд элсэгчдийн жагсаалтын эхний 90-д багтсан элсэгч)

5.15.“Эрх зүй” хөтөлбөрт элсэгчдээс нэмэлт шалгалт авахгүй.

5.16. “Эрх зүй” хөтөлбөрт тэнцсэн тухай мэдэгдэл хүлээн авсан элсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж 5.13.4-т заасан хугацаанд биечлэн ирж бүртгүүлнэ:

5.16.1. иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;

5.16.2. бүрэн дунд боловсролын гэрчилгээ эх хувь;

5.16.3. суралцагчийн хувийн хэрэг эх хувь;

5.16.4. цээж зураг - 3x4 хэмжээтэй 2 хувь;

5.16.5. сургалтын удирдлага, мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөр, Apton англи хэлний хөтөлбөрийн ном, сурах бичгийн төлбөр, Сургалтын төлбөрийг төлсөн баримт;

Зургаа. Ур чадварын шалгалт

6.1. “Цагдаа судлал”, “Мөрдөх алба”, “Кибер гэмт хэрэг судлал”, “Дотоодын цэрэг судлал”, “Хил судлал”, “Шалган нэвтрүүлэх алба”, “Хил хамгаалалтын инженерийн байгууламж, техник хэрэгслийн ашиглалт”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл”, “Аюулгүй байдал судлал”, “Онцгой байдал-гамшиг судлал”, “Шинжлэн магадлах ухаан” хөтөлбөрүүдэд элсэгч нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүгнэлтээр тэнцсэн бол ур чадварын шалгалтад хамрагдана.

6.2. Шалгалтыг Их сургуулийн захирлын тушаалаар баталсан комисс удирдамжийн дагуу зохион байгуулна.

6.3. Ур чадварын шалгалтыг удирдамжид заасан шалгуураар 5 дасгалын авбал зохих 100 онооноос чанар тус бүрийн нийлбэр 62 буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцэнэ.

6.4. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор арван орны нарийвчлалтайгаар үнэлнэ. Энэхүү үнэлгээ нь анхны оноо болно.

6.5. Анхны онооны гүйцэтгэлийн хувиар хэмжээст оноог тооцож гаргана.

Хэмжээст оноог дараах аргачлалаар бодно:

д/д	Анхны оноо (А)	Хэмжээст оноо (Х)	Бодох томьёо
1	0-59	200-479	$X=200+A*4.66$
2	60-64.9	480-519	$X=480+(A-60)*8$
3	65-69.9	520-559	
4	70-74.9	560-599	
5	75-79.9	600-639	
6	80-84.9	640-679	
7	85-89.9	680-719	
8	90-94.9	720-759	
9	95-100	760-800	

6.6. Ур чадварын шалгалтын оноо (30 хувь) болон ЭШ-ын оноо (70 хувь)-ны нийлбэрийг үндэслэн буурах дарааллаар эрэмбэлэн хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэгчийг дараагийн нэмэлт шалгалтад оруулна.

Долоо. Элсэлтийн нэмэлт шалгалт

7.1. Нэмэлт шалгалтын төрөл:

д/д	Нэмэлт шалгалт	Шалгуур үзүүлэлт
7.1.1	“Эрүүл мэндийн үзлэг”-ийг Төрийн тусгай албан хаагчдын албан нэгдсэн	-Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба

	эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулна.	хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам"-д заасны дагуу Эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, шинжилгээ өгч, дүгнэлт гаргуулсан байх; -Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралгүй байх; -Биеийн ил харагдах хэсэгт шивээсгүй байх; (офицер, ахлагчийн алба хаах үед цэргийн дүрэмт хувцас өмссөн үед далдлагдсан бол, өгүүлэмжийг харна) (журмыг дараах холбоосоор дарж үзнэ үү. https://tinyurl.com/234cmk7a)
7.1.2	Бие бялдрын шалгалт	Хүч, тэсвэр, уян хатан, хурд, авхаалж самбаа гэсэн 5 чанар тус бүрээр зохих шалгуур хангасан байх;
7.1.3	Сэтгэл зүйн сорил, ярилцлага	Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэн бодох чадвар, мэргэжлийн сонголт хийж буй сэтгэл зүйн хандлагын түвшнийг тодорхойлно.
7.1.4	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт	Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад тэнцэж тангараг өргөсөн байх; Энэ журмын 8 дугаар бүлгийг үзнэ үү.

7.2. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэгчийг бие бялдрын нэмэлт шалгалтад хамруулна.

7.3. Бие бялдрын шалгалтыг энэ журмын 6 дугаар бүлэг заасан шалгуурын дагуу зохион байгуулна. Бие бялдрын шалгалтад тэнцээгүй элсэгчийг бүртгэлээс хасаж, дараагийн нэмэлт шалгалтад оруулахгүй.

7.4. Сэтгэл зүйн сорил, ярилцлагад хамрагдаж тэнцээгүй болон нөхцөлтэй тэнцсэн элсэгчийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ)-ийн нарийн мэргэжлийн оношилгоонд хамруулан дүгнэлт гаргуулна. Дүгнэлтийг үндэслэн элсэлтийн шалгалтын комисс тэнцүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

Найм.Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт

8.1. Нэмэлт шалгалтад тэнцсэн элсэгчийг цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад /цаашид "ЦХАШМОС" гэх/ хамруулна.

8.2. ЦХАШМОС-д хамрагдах элсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

8.2.1. Эрүүл мэндийн даатгал /2026 оны 09 дүгээр сар хүртэл хугацааны даатгалыг бүрэн төлсөн байх/;

8.2.2. Гэнэтийн ослын даатгалд даатгуулсан баримт;

8.3. ЦХАШМОС-д явах цуваа хөдлөх цагт ирээгүй элсэгчийг бүртгэлээс хасаж, олгосон хувцас хэрэгслийн үнийг төлүүлнэ.

Ес.Хөнгөлөлт үзүүлэх нөхцөл

9.1. Төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаад нас барсан, хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсан алба хаагчийн гэр бүлийн хамаарал бүхий этгээд босго онооны шалгуурыг хангасан бол элсэн суралцахад дэмжлэг үзүүлж болно.

9.2. ДХИС болон захиалагч байгууллагад ажиллаж байгаа алба хаагчийн энэ журмын 2 дугаар бүлэгт заасан нийтлэг болон тусгай шаардлага хангасан хүүхдийг элсүүлэн суралцуулахад дэмжлэг үзүүлж болно. Урьд нь 3 жилийн дотор дэмжлэг авсан алба хаагчийн хүсэлтийг хүлээн авахгүй.

9.3. Энэ журмын 9.2-т зааснаар элсэх тохиолдолд төрсний бүртгэлийн лавлагаа болон тухайн байгууллагын дарга дэмжсэн байна.

9.4.Эрх зүйн хөтөлбөрт элсэгч суурь хичээлд 800 оноотой бол сургалтын төлбөрөөс 1 жил чөлөөлнө.

9.5.ДХИС-ийн харъяа Ахлагч мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн хөтөлбөрт амжилттай суралцсан төгсөгчийг энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд сургуулийн тодорхойлолтыг үндэслэн тухайн мэргэжлийн хөтөлбөрт нэмэлт шалгалтгүйгээр шууд элсүүлнэ.

9.6.Боловсролын яамнаас тогтоосон “Математик”, “Нийгэм судлал”, “Англи хэл”, “Монгол хэл”-ний олон улсын болон улсын олимпиад болон спортоор тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 1-ээс 3-р байр эзэлсэн бүртгүүлэгчдэд энэ журмын 2 дугаар бүлгийн нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан тохиолдолд дэмжлэг үзүүлж болно.

9.7.Энэ журмын 9.6-д заасаар элсэх тохиолдолд нотлох баримтыг харгалзан үзэж, элсэлтийн шалгалтын комисс болон ДХИС-ийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн дүгнэлтийг үндэслэн гаргасан амжилтаар нь эрэмбэлж элсэлтийн шалгалтын комиссын хурлаар тус тус шийдвэрлэнэ.

Арав.Элсэлтийн шалгалтын комисс

10.1.Элсэлтийн үйл ажиллагааг Элсэлтийн шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/ зохион байгуулна.

10.1.1.цагдаагийн байгууллагаас энэ журмын 3.1.1-т заасан хөтөлбөрүүдэд элсэлтийн шалгалтын журмын босго оноо давж, хяналтын тоонд багтаж тэнцсэн элсэгчдийн хувийн байдлыг тогтоосон дүгнэлтийг харгалзан тэнцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

10.2.Комисс болон комиссын дарга Их сургуулийн захирлын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам”-д заасан чиг үүрэг, бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

10.3.Комиссын дарга энэ журмаар зохицуулаагүй асуудлыг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Арван нэг.Элсүүлэх шийдвэр гаргах

11.1.Комиссын хуралдаанаар элсэлтийн шалгалтын дүнг хэлэлцэн, шалгуур хангаж, шалгалтад тэнцсэн элсэгчийг сонгосон хөтөлбөрт элсүүлэн суралцуулах саналыг Их сургуулийн захиралд танилцуулна.

11.2.Комиссын саналыг үндэслэн Их сургуулийн захирал тушаал гаргана.

11.3.Цэргийн хэргийн анхан шатны сургалтад бүрэн хамрагдаагүй, сургалтын явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтыг орхисон, сахилгын зөрчил гаргасан, сургалтын төвийн даргын зөвшөөрөлгүй байрлалыг орхин явсан, өөрийн хүсэлтээр сургалтаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан болон цэргийн тангараг өргөөгүй элсэгчийг элсүүлэн суралцуулахгүй.

Арван хоёр.Элсэлтийн шалгалтын зардал

12.1.Элсэгч дор дурдсан зардлыг хариуцна:

12.1.1.эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр;

12.1.2.гэнэтийн ослын даатгалын төлбөр;

12.1.3.цэргийн хэргийн бэлтгэл сургалттай холбоотой зардал;

12.1.4. сургалтын удирдлага мэдээллийн систем ашиглалтын төлбөр;

12.1.5. Apton англи хэлний хөтөлбөрийн ном сурах бичгийн төлбөр

12.2. Энэ журмын 11.3-т заасан тохиолдолд сургалтын явцад гарсан зардал болон их сургуулиас тавьж олгосон хувцас хэрэглэл, хоол хүнсний зардлыг элсэгч төлөх үүрэгтэй.

12.3. Энэ журамд заагаагүй төлбөр, хураамж, хандив авахыг хориглоно.

Арван гурав. Өргөдөл, гомдол шийдвэрлэх

13.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл, цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалттай өргөдөл, гомдлыг 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл тус тус хүлээн авна.

13.2. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг Их сургуулийн захирал 5 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

13.3. Өргөдөл, гомдлыг хариуг биечлэн амаар буюу утсаар эсхүл бичгээр мэдэгдэнэ. Хариуг амаар, утсаар мэдэгдсэн алба хаагч энэ тухай тэмдэглэл үйлдэж материалд хавсаргана.

Арван дөрөв. Сургалтын төлбөр, төлөх зарчим

14.1. Сургалтын төлбөрийг төрөөс хариуцдаг бакалаврын өдрийн хөтөлбөрт тэнцсэн элсэгч Сургалтын удирдлага, мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөрийг 2026 оны 07 дугаар сарын 09-ний дотор төлнө.

14.2. “Эрх зүй” хөтөлбөрт тэнцсэн элсэгч сургалтын удирдлага, мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөрийг 2026 оны 07 дугаар сарын 09-ний дотор төлнө.

14.3. Элсэгч нь зохих шаардлага хангасан бол төрийн болон бусад байгууллагаас олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээлд хамрагдаж болно.

Арван тав. Бусад зүйл

15.1. Элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэдэд “тэнцсэн” болон “тэнцээгүй” тухай бүртгэгдсэн гар утас болон и-мэйл хаягаар мэдэгдэнэ. Тэнцсэн тухай мэдэгдэл авсан элсэгч заасан хугацаанд ирж нэмэлт шалгалтад ороогүй, эрх зүй хөтөлбөрт элсэгч 5.13.3-т заасан хугацаанд бүртгүүлээгүй бол тэнцсэн элсэгчийн жагсаалтаас хасна.

15.2. Элсэгч нь Боловсролын яамнаас тогтоосон үндэсний хэмжээний ЭШ-ын босго оноог хангасан боловч энэ журмаар тогтоосон тухайн хөтөлбөрт хамаарах босго онооны шаардлага хангаагүй бол элсүүлэхгүй.

15.3. Нэмэлт шалгалтад тэнцсэн боловч бүртгүүлсэн хөтөлбөрийн хяналтын тоонд багтаагүй элсэгчийг бүртгэлээс хасна.

15.4. Элсэлтийн шалгалтын комисс нь энэ журмын 15.3-т заасны дагуу хасагдсан элсэгчид хяналтын тоонд хүрээгүй бакалаврын хөтөлбөрт эсхүл мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт бүртгүүлэхийг санал болгож болно.

15.5. Элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн мэдээллийг холбогдох баримт бичгүүдийн эх хувьтай тулган шалгах бөгөөд худал мэдүүлсэн тохиолдолд элсэлтийн бүртгэл болон тэнцсэн элсэгчдийн жагсаалтаас хасна.

15.6. Элсэгчийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад баримт

бичиг засвартай, хуурамч байж болзошгүй тохиолдолд элсэгчдийн жагсаалтаас хасаж, харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлнэ.



ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/157 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЭЛСЭГЧДЭЭС АВАХ УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг.Хамрах хүрээ.

1.1.Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэгч хамрагдана.

Хоёр.Зохион байгуулалт, газар, хугацаа.

2.1.Их сургуулийн захирлын тушаалаар баталсан комисс шалгалтыг зохион байгуулна.

2.2.Ур чадварын шалгалтыг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулна. (Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан товлосон хугацаа өөрчлөгдөж болно)

2.3.Ур чадварын шалгалт Их сургуулийн байрлалд явагдана.

Гурав.Шалгалтын бэлтгэл.

3.1.Элсэгчид ур чадварын шалгалтад ирэхдээ спорт зааланд өмсөх зориулалтын пүүз, бэлтгэлийн хувцас, хөлсний алчуур, цэвэр ус болон бусад хувийн бэлтгэлээ сайтар хангаж ирнэ.

Дөрөв.Шалгалтын төрөл, үнэлгээ, гүйцэтгэх аргачлал.

4.1.ДХИС-д элсэгчдээс Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны А/545 дугаар тушаалаар баталсан "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-д заасан бие бялдрын бэлтгэлжилтийн нормативт 5 дасгалаар шалгалт авч 100 онооны системээр дүгнэнэ.

4.2.Нормативт 5 дасгалын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь нь 60 ба түүнээс дээш үнэлгээ авсан тохиолдолд тэнцэнэ.

4.3.Шалгалтыг дараах ангилал, нормативаар шалгаж, үнэлнэ:

4.3.1.17-25 насны шалгуулагчийн норматив.

Үнэлгээ	Хүч		Тэсвэр		Хурд		Авхаалж самбаа		Уян хатан	
	Савлуурт суниах	Гэдэсний таталт	1000м		100м		I цогцолбор		Урагш бөхийх	
			/Эр/	/Эм/	/Эр/	/Эм/	/Эр/	/Эм/	/Эр/	/Эм/
100	20	58	3.20	4.20	13.0	15.0	120	90	60	60
99			3.22	4.23		15.1				
98			3.24	4.26	13.1	15.2	119	89	59	59
97		57	3.26	4.29		15.3				
96	19		3.28	4.32	13.2	15.4	118	88	58	58
95			3.30	4.35		15.5				
94		56	3.32	4.38	13.3	15.6	117	87	57	57
93	18		3.34	4.41		15.7				
92		55	3.36	4.44	13.4	15.8	116	86	56	56
91			3.38	4.47		15.9				
90	17	54	3.40	4.50	13.5	16.0	115	85	55	55



89			3.42	4.53		16.1				
88			3.44	4.56	13.6	16.2	114	84	54	54
87		53	3.46	4.59		16.3				
86	16		3.48	5.02	13.7	16.4	113	83	53	53
85			3.50	5.05		16.5				
84		52	3.52	5.08	13.8	16.6	112	82	52	52
83	15		3.54	5.11		16.7				
82		51	3.56	5.14	13.9	16.8	111	81	51	51
81			3.58	5.17		16.9				
80	14	50	4.00	5.20	14.0	17.0	110	80	50	50
79			4.02	5.23		17.1				
78			4.04	5.26	14.1	17.2	109	79	49	49
77		49	4.06	5.29		17.3				
76			4.08	5.32	14.2	17.4	108	78	48	48
75	13	48	4.10	5.35		17.5				
74			4.12	5.38	14.3	17.6	107	77	47	47
73		47	4.14	5.41		17.7				
72			4.16	5.44	14.4	17.8	106	76	46	46
71		46	4.18	5.47		17.9				
70	12		4.20	5.50	14.5	18.0	105	75	45	45
69		45	4.22	5.53		18.1				
68			4.24	5.56	14.6	18.2	104	74	44	44
67	11	44	4.26	5.59		18.3				
66			4.28	6.02	14.7	18.4	103	73	43	43
65		43	4.30	6.05		18.5				
64	10		4.32	6.08	14.8	18.6	102	72	42	42
63		42	4.34	6.11		18.7				
62	9		4.36	6.14	14.9	18.8	101	71	41	41

Тав.Бие бялдрын нормативын дасгалыг гүйцэтгэх аргачлал.

Нэг. Хүч:

Савлуурт суних, /Эрэгтэй/

“Эхэл” командаар суга савлуурын өнцөг дээр үсрэн гарч, гар дээр шулуун тулж, цээжийг түхийлгэн, биеийг нуруугаар хагас хотойн чангалж, хоёр хөлийг шулуунаар нийлүүлэн, өлмий жийсэн байдлаас суниана. Доошлохдоо гарыг 90 градусаас дотогш нугалж, дээш түлхэхдээ тохойг гүйцэт тэнийлгэнэ. Гарыг тохойгоор дутуу нугалах, дутуу түлхэх, хөлийг өвдөгөөр нугалах, тонгойх, хотойж савах хөдөлгөөнийг ашиглан гүйцэтгэхийг хориглоно.



Гэдэсний таталт, /Эмэгтэй/

Бэлтгэх байдал : Хөлийг 30 см – ээс илүүгүй салгасан /хөл нийлүүлж гүйцтэхийг хориглохгүй/, өвдгийг 90о–аас дотогш өнцөгөөр нугалсан байдлаар газарт сууж, толгой, тааз хоёр босоо нэг шугаманд, хоёр гарыг тохойгоор нугалан цээжний өмнө зөрүүлэн биедээ наасан байна. Хөлийг зөвхөн шагайн үе хэсэгт хоёр гараар дарна.



Дасгалыг гүйцэтгэх: “Эхэл” командаар арагш хэвтэн хоёр далыг газарт хүргээд эхлэх байдалд шилжих хөдөдгөөнийг үргэжлүүлэн хийнэ. Дасгалыг 2 минутын хугацаанд гүйцэтгэнэ. Дасгалыг гүйцэтгэх явцад гарыг биенээс салахгүйгээр суугаа байдлаар амарч болно. Хоёр гарыг биенээс салгах, татаж, тулж босох, тохойн хэсгээр савалт хийх, далыг газарт хүргэхгүй байх, хэвтэж амрах, тааз өргөх ба нуруугаар хотойн гүйцэтгэснийг тооцохгүй.

Хоёр.Тэсвэр:

▣ 1000 метрийн гүйлт, /эрэгтэй, эмэгтэй/

Бэлтгэх байдал : “Гараандаа” командаар гарааны шугамны ард нэг хөлийг урагш тавьж өвдөг болон хоёр гарын хагас нугалж, цээжийг урагш унагасан байдлаар гүйхэд бэлтгэн зогсоно.

Дасгалыг гүйцэтгэх: “Марш” командаар гараанаас гарч маршрутын дагуу гүйж барианд орно.



Гурав.Хурд:

▣ 100 метрийн гүйлт, /эрэгтэй, эмэгтэй/

Бэлтгэх байдал: “Гараандаа” командаар гарааны шугам руу зөөлөн гүйж /алхаж/ очин, нэг хөлийн өлмийг гарааны шугамнаас хойш нэг бүтэн, нэг хөндлөн ул тавьсан хэмжээтэй зайд байрлуулан, нөгөө хөлийг гэдрэг хагас алхан, өвдөгөөр

тулж сууна. Хоёр гарыг гарааны шугам дээр мөрний хэмжээнээс илүү зайтайгаар гарын тохой шулуун, алгыг хагас атгасан байдлаар хуруугаар газарт тулсан байна.



Дасгалыг гүйцэтгэх: “Анхаар” командаар газарт тулсан өвдөг болон таазыг өргөн, толгой, цээжээр урагш бөхийж биеийн жинг гар дээр шилжүүлнэ. Гарыг тохойгоор нугалахгүй, “Марш” командаар хоёр хөлийн тэсрэх түлхэлтийг гарын савалттай хослуулан гүйлтийг эхэлнэ.


Дөрөв.Авхаалж самбаа

□ I цогцолбор дасгал, /эрэгтэй, эмэгтэй/

Дасгалд багтсан бөхийлт, гар дээр суниах, гэдэсний таталт, эргэлттэй үсрэлт гэсэн дасгалуудыг дээрх дарааллын дагуу тус дасгал бүрийн 30 секундэд дээд зэргийн хурдтай гүйцэтгэнэ. Дасгал хооронд 30 секундын амралт авна. Дөрвөн дасгалын гүйцэтгэсэн давтамжийн тооны нийлбэрээр үнэлнэ.

Бөхийлт

Бэлтгэл байдал: Хөлийг мөрний хэмжээний зайтай, гарыг ташаанд авсан байдлаар цэх зогсоно.



Дасгалыг гүйцэтгэх: “Эхэл” командаар бөхийж хоёр гарын үзүүрийг тэнийлгэж газарт хүргэн, буцаж өндийн эхлэх байдалд орох дасгалыг тасралтгүй гүйцэтгэнэ. Өвдөгөөр нугалах болон дээш өндийх үед гарыг ташаанд аваагүй, биеийг цэх байдалд оруулаагүй бол гүйцэтгэлд тооцохгүй

Гар дээр суниалт.

Бэлтгэх байдал: Гарыг мөрний хэмжээний зайд тулж, гарын хуруу урагш байрлалтай газар тулж өвдөглөсөн байна. “Анхаар” командаар өвдгийг өргөж, биеийг чангалан тохой, өвдөг шулуун болгож, толгойг өргөсөн, хөл нийлүүлсэн байна.



Дасгалыг гүйцэтгэх: “Эхэл” командаар биеийн шулуун байдлыг хадгалан гарыг тохойн үеэр нугалж мөрийг тохойн түвшинд хүргэн буцаж эхлэх байдалд орох дасгалыг тасралтгүй гүйцэтгэнэ. Дасгалыг гүйцэтгэх явцад биеийн аль нэг хэсгээр газар шүргэх, тохойг мөрний түвшинд хүртэл нугалаагүй, биеийн шулуун байдлыг хадгалж чадаагүй, гарын алга, хөлийн өлмийнөөс өөр биеийн аль нэг хэсэг газарт хүрсэн тохиолдолд бүрийг гүйцэтгэлд тооцохгүй.


Гэдэсний таталт.

Бэлтгэх байдал : Биеийг шулуун, хөлийг нийлүүлэн, гарыг шилэн хүзүүнд зөрүүлж барьсан байдлаар газарт дээш харан хэвтэнэ.



Дасгалыг гүйцэтгэх: “Эхэл” командаар хоёр гарын савалтаар өндийж урагш бөхийн хоёр гарыг тэнийлгэн үзүүр хэсгийг хөлийн өлмийд хүргээд, буцаж гарыг шилэн хүзүүнд аван хэвтэх дасгалыг үргэжлүүлэн хийнэ. Дасгалыг хийх хугацаанд далаар газарт хүрч, хоёр хөл нийлсэн, өвдөг шулуун, хөл газраас хөндийрөхгүй байна.

Эргэлттэй үсрэлт.



Бэлтгэл байдал: Хөлийг мөрний хэмжээний зайтай, гарыг ташаанд авсан байдлаар цэх зогсоно.

Дасгалыг гүйцэтгэх : “Эхэл” командаар бүтэн биеэр 180 градусын эргэлтийг үсрэлтээр хийж, буцаж үсрэн эргэж эхлэх байдалдаа орох дасгалыг тасралтгүй гүйцэтгэнэ. Хоёр эргэлт /360o/- ийг 1 тоонд тоолно. Эргэлтийг зөвхөн нэг тал руугаа эргэх, эсвэл дутуу эргэлт хийх буюу хоёр хөл 180 градусаар эргэх явцад нэг шугаманд байрлахгүй байх, толгой биеийг хамт эргүүлэхгүй байх тохиодолд давтамжийн тоог тооцохгүй.


Тав.Уян хатан

□ Урагш бөхийх, /Эрэгтэй, эмэгтэй/

Бэлтгэх байдал : Суугаа байдалд хоёр хөлийг нийлүүлэн шулуун хийж, тусгай дугуйт тавцанг дээгүүр нь байрлуулан, тавцангийн өөрийн талын ирмэг хэсэгт 2 гарын алгыг доош харуулан мөрний хэмжээний зайнд байрлуулж, эрхий болон долоовор хурууны хонхор хэсгийг тулган барина.



Дасгалыг гүйцэтгэх: “Эхэл” командаар гараар тавцанг түлхэн урагш бөхийж өвдөг нугалахгүйгээр эцсийн боломжоо хүртэл сунган 5 секундын хугацаанд барьж гүйцэтгэнэ. Шалгуулагчийн өвдөгний үенээс түлхэгдсэн тавцангийн өөрийн талын ирмэг хүртэлх зайг хэмжиж үнэлгээг өгнө.



ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ